

“ГЕРМЕС ЦЕНТР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2015 оны 4-р сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Хурал 2015 оны 4-р сарын 15-ны өдөр компанийн өөрийн байрны 3 давхарт байрлах хурлын танхимд 15.10 цагаас эхэлж боллоо. Хуралд жил болгон хүрэлцэн ирдэг хувьцаа эзэмшигчид ирсэн байлаа. Хурлыг цагтаа нээж, ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн үг хэллээ.

ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн : Компанийн тухай хуулийн дагуу хурлын ирц хангалттай болсон байх гэж үзээд, хурлаа эхлэхэд боломжтой болов уу гэж бодож байна. Хурлын ирцийг бүртгэж суугаа хурал зохион байгуулах комиссын ажилтан нар удахгүй хурлын ирцийг танилцуулах болно. Компанийн хурлын ирцийг бүртгэх тооллогын комиссын гишүүд О.Энхтуяа, З.Гончигсүрэн нар бүртгэлээ танилцуулна уу.

Тооллогын комиссын гишүүн З.Гончигсүрэн : Хурлын ирц 15.10 цагийн байдлаар 84.3 хувьтай байна. Хурлын явцын дунд хувьцаа эзэмшигчид хүрэлцэн ирж дууссаны дараа дахин тооллогын дүнг та бүхэнд танилцуулах болно.

ТУЗ-ийн буюу хурлын дарга Д.Оюунсүрэн : Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаа хүрэлцэн ирсэн та бүхэндээ баярлалаа. Өнөөдрийн хурлаар 7 асуудал хэлэлцэнэ. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт болон хурлын дэг нь та бүхэнд тараагдсан хурлын материалд байгаа. Хурлын ирц хангалттай байгаа тул хурлаа эхэлье. Хэлэлцэж байгаа асуудал бүр дээр хувьцаа эзэмшигчид тус бүр саналаа хэлж болно.

1. Хэлэлцэх асуудал : Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийн тухай. Хэлэлцүүлэгч Гүйцэтгэх захирал Ш.Баасанжсав.

Өнгөрсөн 2014 онд “Гермес центр” ХКомпани нь Эрдэнэт хот дахь өөрийн компанийн Худалдааны төвийн барилгыг худалдан борлуулж, Улаанбаатар хот дахь барилгын материалын Худалдааны төвд барилгын засварын ажлыг шинээр хийж гүйцэтгэн, худалдааны төвийн павильонуудыг худалдаалж буй бараа материалаар нь төрөлжүүлэн байрлуулах зэрэг өөрчлөлт шинэчлэлтийн ажлыг хийж ажиллалаа.

Удирдлага зохион байгуулалтын хүрээнд компани нь нийт 21 ажиллагсадтайгаар компанийн үйл ажиллагаагаа явууллаа. УБ хотын худалдааны төвд засварын ажил хийж гүйцэтгэсэн. Та бүхэнд санхүүгийн тайлангаа танилцуулья

1. Компанийн санхүүгийн тайлангийн үндсэн үзүүлэлтүүд :

- Нийт хөрөнгө 8 422.4 сая төгрөг бөгөөд үүнээс :
- Эргэлтийн хөрөнгө 1 325.1 сая төгрөг
- Үндсэн хөрөнгө 7 097.2 сая төгрөг
- Эзэмшигчийн өмч хөрөнгө 7 854.3 сая төгрөг
- Нийт цэвэр ашиг 816.4 сая төгрөг буюу нийт хөрөнгийн дүнтэй харьцуулахад өр төлбөр 2.6 %, эзэмшигчийн өмч 97.4 %, хуримтлагдсан ашиг 9.7 % байна.

2. Татварын өр төлбөрийн тухай : Нийт компанийн хэмжээнд татварын өр төлбөр 2014 онд ААН-ийн ОАТатварт 89.8 сая төгрөг, ажиллагсдын цалингаас суугтасан хувь хүнийн ОАТатварт 24.6 сая төгрөг, НӨАТатварт 233.4 сая төгрөг, үл хөдлөх эд хөрөнгийн албан татварт 48.9 сая төгрөг, газрын төлбөрт 6.0 сая төгрөг нийтдээ улсын татварт 402.8 сая төгрөгийн татвар төлсөн бөгөөд манай компани оны эцэст татварын ямарваа нэгэн өр төлбөргүй ажилласан болно.

төсөвлөсөн 1 427.9 сая төгрөгийн борлуулалтын орлогын дүнтэй харьцуулахад 95.7 %-ийн биелэлттэй гарлаа.

4. Зардлын тухай :Компанийн хэмжээгээр 2014 онд 718.2 сая төгрөгийн зардал гаргасан болно. Зардлын төлөвлөгөө 764.8 сая төгрөг байсантай харьцуулахад төлөвлөгөөний биелэлт 93.9%-ийн биелэлттэй гарсан. Компанийн хэмжээгээр зардлыг төлөвлөснөөс 46.6 сая төгрөгөөр хэмнэж ажилласан болно.
5. Ашгийн тухай : Компанийн хэмжээгээр 2014 онд 816.4 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан. Ашгийн төлөвлөгөө 596.7 сая төгрөг байсантай харьцуулахад ашгийн төлөвлөгөөг 136.8%-иар буюу 219.7 сая төгрөгөөр давуулан биелүүлж ажиллалаа.
6. Нэгж хувьцааны ногдол ашгийн тухай : Аудитын байгууллагаар баталгаажсан 2014 оны санхүүгийн тайлан балансаар тус компани нь нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн төлөвлөгөөг дараах байдлаар биелүүлэв. Үүнд :
 - 2014 оны нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн төлөвлөгөө 7 төгрөг 60 мөнгө
 - 2014 оны санхүүгийн тайлангаар нэгж хувьцаанд оногдох ногдол ашгийн хэмжээ 10 төгрөг 39 мөнгө болж гарсан.

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь гүйцэтгэх удирдлагын багийн ажлыг хангалттай сайн ажилласан гэж дүгнэсэн болно. Өнгөрсөн жилийн ажлаа товч танилцуулахад ийм байна. Асууж тодруулах асуудал байвал та бүхэнд нээлттэйгээр хариулахад миний бие бэлэн байна.

ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн : Компанийн дүрмээр ТУЗ-ийн дарга хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар сонгогдон ажилладаг тул миний бие нь хурлын даргын үүрэгт ажлаа гүйцэтгэж байгааг та бүхэн мэдэж байгаа гэдэгт итгэлтэй байна. Гүйцэтгэх захирлын тайлангаас асууж тодруулах, мөн дэлгэцэн дээр гаргасан байгаа сүүлийн 5 жилийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдээс асуух зүйл байна уу. Манай компанийн хувьд сүүлийн 5 жилийн байдлаар санхүүгийн үзүүлэлтүүд маань өссөн дүнтэй байгаа, жил болгон хувьцаа эзэмшигчдэд оногдох ногдол ашгийн хэмжээг нэмэгдүүлэн ажиллаж ирсэн. Манай гүйцэтгэх удирдлагын баг ТУЗ-өөс өгсөн үүрэг даалгаврыг сайн биелүүлэн ажилласан гэж бид дүгнэж байна.

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн : Эрдэнэт хот дахь салбарын барилгыг хэдэн төгрөгөөр борлуулсан бэ, компанийн 2014 оны ногдол ашигт тусгагдсан байгаа юу. Хөрөнгө өссөн үү.

Чягтлан бодогч О.Энхтуяа : Эрдэнэт хот дахь салбарын барилгыг УБ хотын “Нэкст электроникс” ХХКомпанид 1 000 000 000.00 /нэг тэрбум/ төгрөгөөр “Худалдах, худалдан авах гэрээ” байгуулан худалдсан болно. Барилгын анхны өртөг нь 806 639 310.00 төгрөг байсан. Барилгын хувьд байгуулагдсан элэгдлийн дүн 88 055 953.32 төгрөг байсан, барилгын үлдэх өртөг буюу анхны өртгөөс элэгдлийн дүнг хассан өртөг 718 583 356.68 төгрөг болсон. Барилгыг худалдан борлуулсны НӨАТатварт 90 909 090.91 төгрөг төлсөн. Үндсэн хөрөнгө борлуулсны 2%-ийн татвар 18 181 818.00 төгрөгийг мөнхүү төлсөн. Эрдэнэт хот дахь салбарын барилгыг худалдан борлуулсны борлуулалтын ашиг 172 325 734.41 төгрөг болсон. УБ хот дахь Худалдааны төвд 833.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг шинээр хийсэн. Худалдааны төвийн Б блокийн доод давхарт шинээр засвар хийснээр манай компанийн борлуулалтын орлого нэмэгдсэн болно. Өмнө нь энэ давхрыг агуулахын зориулалтаар түрээсэлдэг байсан бол худалдааны павильоны болгон түрээсэлж байгаа юм. Тийм учраас ашгийн төлөвлөгөөг давуулан биелүүлсэн болно. Компанийн хөрөнгө бол энэ дүнгээр өссөн болно.

Гүйцэтгэх захирал Ш.Баасанжав : УБ хот дахь худалдааны төвийн бүх давхруудад иж бүрэн галын дохиоллын болон усжуулалтын системийг суулгасан. ОО-ын давхрыг бүрэн павильонжуулсан болно. Өөрөөр хэлбэл бид ашигтай, өгөөж өгөх түрээсийн талбайгаа нэмэгдүүлсэн болно. Эрдэнэт

нутагт түрээсийн бизнесийн үйл ажиллагаа явуулах нь оновчтой биш байсан гэдэг утгаар манай компанийн ТУЗөвлөл нь дээрх шийдвэрийг гаргаж хэрэгжүүлсэн юм.

- *Хэлэлцсэн 1-р асуудлаар гаргасан шийдвэр : Хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг үндэслэн Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг сайшааж, хурлын тэмдэглэлд оруулах.*

2. Компанийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын байгууллагын дүгнэлт. Хэлэлцүүлэгч нягтлан бодогч О.Энхтуяа

Манай компани “Юдентакс Тин Аудит”ХХК-иар аудитын тайлангаа баталгаажуулсан. Аудитын дүгнэлтийг та бүхэнд уншиж танилцуулья. “Бидний дүгнэлтээр аудитласан санхүүгийн тайлан нь Гермес центр ХК-ийн 2014 оны 12-р сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын Олон улсын стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна” гэж бидний санхүүгийн тайланг дүгнэсэн болно. Хувьцаа эзэмшигч та бүхэнд байгаа хурлын материал дотор манай компанийн Санхүүгийн байдлын тайлан, Аудиталсан орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан тус тус хавсаргагдсан байгаа. Та бүхэн асууж тодруулах зүйл байна уу. Гүйцэтгэх захирлын илтгэлд мөнхүү санхүүгийн үзүүлэлтүүд дурьдагдсан болно.

Хувьцаа эзэмшигч Г.Мөнхэрдэнэ : Мөнгөн гүйлгээний тайлан дээр бусад мөнгөн орлого 1 698 тэрбум төгрөг байгааг задалж хэлнэ үү. Бөөн дүнгээр бичсэн байгааг задаргаа хийж танилцуулж байвал яасан юм бэ. Элэгдлийн зардлыг хаана тусгасан байна бэ.

Нягтлан бодогч О.Энхтуяа : Эрдэнэтийн салбарын барилга борлуулсан орлого, борлуулалтын орлого нийт дүнгээрээ бичигдсэн байна. Орлогын дэлгэрэнгүй тайлан дээр тусгагдсан байгаа. Та бүхэн дэлгэрэнгүй тайланг компанийн вэб сайтаас харж болно.Элэгдлийн зардал мөн тусгагдсан байгаа.

ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн : Та бүхэнд сүүлийн 5 жилийн орлого, зарлага, ашгийн графикийг танилцуулж байна. Өмнөх жилээс орлого байнга өсөж ирсэн. Жил болгон өсөлттэй явж байна. Ирэх 2 жилд компанийн зүгээс том бүтээн байгуулалтын ажил хийгдэхгүй. Харин худалдааны төвийн барилга байшингаа тордох засварын ажлууд бол хийгдэнэ.

Нягтлан бодогч О.Энхтуяа : Дэлгэцэн дээрээс эргэлтийн болон эргэлтийн бус хөрөнгийн харьцааг танилцууллаа. Энэ худалдааны төвийн байшин байгаа газар маань эргэлтийн бус хөрөнгөнд бүртгэгдсэн байгаа болно.

Хувьцаа эзэмшигч Г.Мөнхэрдэнэ : Танай өрсөлдөгч ямар компани байна вэ. Судалгаа байна уу.

ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн : Манай компанийн худалдааны төв бол бүх төрлийн барилгын материал худалдаалдаг төрөлжсөн, орчин үеийн худалдааны төв байхаар зорилго тавьж ажилладаг. Яг өрсөлдөгч гэж өөр зах худалдааны төвийг хардаггүй. Харин хамтрагчид гэж хардаг, манай худалдааны төвийн давуу тал нь төрөлжсөн, худалдан авагчдын эрх ашигт нийцсэн барилгын сайн чанарын материал худалдаалдаг, мөн нийтийн эрх ашгийг хангасан автомашины зогсоол сайтай байх нь чухал гэж хардаг. Өөр салбар шинээр байгуулах боломжийг судлахгүй байгаа. Түрээслэгчид маань валютын ханшаас маш их хамааралтай ажилладаг бизнес эрхлэгчид байдаг. Нөгөө талаасаа эдийн засгийн энэ их савалгаатай, үнэ ханшийн өөрчлөлттэй үед бид хамаагүй шинэ салбар байгуулах боломжийг хайхыг эрэлхийлэхгүй байна. Харин одоо байгаа худалдааны төвөө

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн : Түрээслэгчдээс гомдол санал гардаггүй юу.

ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн : Бид дотоод менежментийг хэрэгжүүлэн ажиллаж байдаг. Сар бүр түрээслэгчдэдээ захидал явуулж байна. Энэ захидлаараа юу болж байна, юу болохгүй байна, үүссэн асуудлуудыг хэрхэн шийдвэрлэсэн, цаашид ямар арга хэмжээ авч ажиллах талаараа байнга сануулж бичиж байдаг. Тийм учраас түрээслэгчдээс гарах санал гомдол багассан, харин түрээслэгчид өөрсдөө үүрэг хариуцлагаа илүүтэй урамсарлаж ажиллах, хэрэглэгчдийг хохироохгүй байх, түрээсийн төлбөрөө цаг хугацаандаа төлдөг байх, төрөлжсөн барилгын материалаа худалдаалдаг байх үүргүүдээ биелүүлдэг болж байгаа. Энэ жилийн хувьд манай компани түрээсийн төлбөрөө нэмэгдүүлээгүй, харин өвлийн эхний 2 сард түрээсийн төлбөрийн хөнгөлөлтийг үзүүлж байгаа. Бидний орлогыг бий болгож байгаа түрээслэгчдэдээ хүндэтгэлтэй хандаж ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигч Г.Мөнхэрдэнэ : Та бүхэн худалдаалж байгаа барааны багцыг зөв бүрдүүлэх тал дээр ямар бодлого барьж байна вэ. Худалдааны төвд ирж байгаа хүмүүсийн талаар судалгаа хийсэн байна уу.

ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн : Бид энэ тал дээр маш их анхаарч ажиллаж байна. Манай худалдааны төвд цемент, шил, модон хавтан, труба гэх мэт хүнд, шороо тоос ихтэй бараа материал бол байхгүй, гэхдээ бусад төрлийн бүх барилгын бараа материалыг борлуулж байгаа. Барилгын материалын зах зээл өсөх гээд байгаа ч юм шиг бид эдийн засгийн байдлаасаа байнга хамааралтай байдаг. Мөн барилгын материал гэдэг нөгөө талаасаа хүн амаасаа маш их хамаарч байдаг, эдийн засгаасаа хараат байдаг нь бидэнд бас нөлөөлж байна. Манай худалдааны төвд УБ хотын болон хөдөө орон нутгийн үйлчлүүлэгчид ирдэг дээ. Энд чанартай материал байвал худалдан авагчид бүгд ирнэ.

Хувь нийлүүлэгч Ч.Жаргал : Өнгөрсөн жил түрээсээ төлөхгүй айл гарсан уу. 5 жилийн төлөвлөгөө хийсэн байгаа юу.

Гүйцэтгэх захирал Ш.Баасанжав : Түрээсээ төлөхгүй айл бараг байхгүй, харин 2 сараар төлөхгүй байх асуудал хааяа нэг гардаг. Манай түрээслэгчид ер нь бол боломжийн өөрсдийн тогтсон бизнестэй түрээслэгчид байдаг. 2 сар төлөхгүй бол шууд мэдэгдэл өгөөд гэрээний дагуу талбайгаа чөлөөлж авдаг юм.

ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн : Ойрын хугацааны төлөвлөгөөг хийж байгаа, олон жилийн төлөвлөгөө хийгээгүй байна. Улс орны эдийн засгийн байдлаас хамаардаг тул хамаагүй олон жилийн төлөвлөгөө хийх сонирхол одоогоор манай ТУЗ-д байхгүй байна. Энэ жилийн хувьд түрээслэгч, хэрэглэгчийн эрх ашигт нийцүүлж, банкны үйлчилгээг илүүтэй болгох зорилгоор ХААН банкны орлого, зарлага зэрэг хийгддэг АТМ машиныг тавиулах гэж байна. Одоо бол манайд Голомт банкны бэлэн мөнгөний АТМ байна.

Хувьцаа эзэмшигч Ж.Баатар : Та бүхэн сүүлийн жилүүдэд бизнесийн үйл ажиллагаагаа сайн явуулж байна гэж үзэж байна. Заавал олон салбартай байх нь зөв биш гэж би үздэг, хамгийн гол нь үр дүн, ашиг чухал. Ашиг үйлдвэрлэхгүй олон салбар нэгжээр яах юм бэ. Зөв алхам хийсэн байна гэж хувьцаа эзэмшигч миний зүгээс үзэж байна.

ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн : Орлого олж өгч байгаа түрээслэгчдэдээ сайн хандахыг хамгийн чухал гэж үздэг. Өөрийн бизнесийн туршлагаасаа харахад тогтвортой бизнесийн үйл ажиллагаа эрхлэх нь чухал гэдгийг миний хувьд сайн мэднэ. Хувьцаа эзэмшигч талаасаа ч, орлого олж өгч байгаа түрээслэгч талаасаа ч, бараа материал худалдан авч байгаа хэрэглэгч талаасаа ч харах хэрэгтэй. Олон өнцгийг нэг өнцөг болгож, нийлүүлж харж чадах нь чухал байна.

- *Хэлэлцсэн 2-р асуудлаар гаргасан шийдвэр : Хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг үндэслэн Компанийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын байгууллагын дүгнэлтийг сайшааж, хурлын тэмдэглэлд оруулах.*

3. Компанийн 2013 оны ногдол ашгийг хуваарилж тараасан тухай мэдээлэл, 2014 оны ногдол ашгийг хуваарилсан болон 2015 оны ногдол ашгийн тухай. Хэлэлцүүлэгч ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн

ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн : Хувьцаа эзэмшигч та бүхэндээ компанийн тухай хуулийн дагуу ногдол ашгаа хэрхэн тараасан, мөн хэрхэн хуваарилсан, бас цаашид ногдол ашгаа хэрхэн тараах талаарх мэдээллээ хүргэе. Энэ асуудлаа хэлэлцсэний дараа хурлаа түр завсарлаж, цай кофены завсарлагааны цагтаа орох уу. Бид зөндөө чөлөөтэй, нээлттэй ярилцаж байна гэж бодож байна. За санал нэг байгаа бол асуудалдаа орох уу.

3.1."Гермес центр" ХК-ийн 2013 оны ногдол ашиг хуваарилж тараасан тухай мэдээлэл

"Гермес центр" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2014 оны 2-р сарын 19-ний өдрийн хурлаас баталсан №4 тоот тогтоолын дагуу 2013 оны цэвэр ашгийг дараах байдлаар хуваарилсан билээ.

Үүнд :

- Цэвэр ашгийг 100 %-р буюу 457 129 534.82 /дөрвөн зуун тавин долоон сая нэг зуун хорин есөн мянга таван зуун гучин дөрвөн төг 82 мөн/ төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгаар хуваарилав.

2014 оны 3-р сарын 6-ны бүртгэх өдрөөр нийт 873 хувьцаа эзэмшигчид байсан бөгөөд тэдгээрт оногдох ногдол ашгийн мөнгөнөөс 6 хувьцаа эзэмшигчдийн 67 286 117 ширхэг хувьцааны ногдол ашиг 390 932 339=77 төгрөгийг компанийн төв байран дээр бэлнээр, 867 хувьцаа эзэмшигчдийн 11 256 884 ширхэг хувьцааны ногдол ашиг 65 402 496.04 төгрөгийг ҮЦТТТХТөвөөр дамжуулан бэлэн бусаар тараасан болно.

3.2."Гермес центр" ХК-ийн 2014 оны ногдол ашгийг хуваарилсан тухай мэдээлэл

"Гермес центр" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг тээдлэн 2014 оны цэвэр ашгийг хагас болон бүтэн жилээр хоёр хувааж хуваарилсан юм. Үүнд :

- 2014 оны эхний хагас жилийн цэвэр ашгийг ТУЗ-ийн 2014 оны 8-р сарын 8-ны өдрийн хурлаас баталсан №12 тоот тогтоолын дагуу цэвэр ашгийн 100 %-ийг буюу 480 103 292.05 /дөрвөн зуун наян сая нэг зуун гурван мянга хоёр зуун ерөн хоёр төг 05 мөн/ төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгаар хуваарилав.

2014 оны 8-р сарын 15-ны бүртгэх өдрөөр нийт 881 хувьцаа эзэмшигчид байсан бөгөөд тэдгээрт оногдох ногдол ашгийн мөнгөнөөс 8 хувьцаа эзэмшигчдийн 67 336 117 ширхэг хувьцааны ногдол ашиг 411 423 674=87 төгрөгийг компанийн төв байран дээр бэлнээр, 873 хувьцаа эзэмшигчдийн 11 206 884 ширхэг хувьцааны ногдол ашиг 68 474 061.24 төгрөгийг ҮЦТТТХТөвөөр дамжуулан бэлэн бусаар тараасан болно.

- 2014 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгийг ТУЗ-ийн 2015 оны 2-р сарын 12-ны өдрийн хурлаас баталсан №2 тоот тогтоолын дагуу цэвэр ашгийн 95 %-ийг буюу 320 000 000.00 /гурван зуун хорин сая төг 00 мөн/ төгрөгийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгаар, 5 %-ийг буюу 16 532 454.36 /арван зургаан сая таван зуун гучин хоёр мянга дөрвөн зуун тавин дөрвөн төг 36 мөн/ төгрөгийг компанийн цалин үндэслэлд

3.3. "Гермес центр" ХК-ийн 2015 оны ногдол ашгийн тухай

"Гермес центр" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2015 онд хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг дээдэлж, 2015 оны санхүүгийн тайланд 2 удаа аудитын дүгнэлт гаргуулж, ногдол ашгийг оны хагас болон бүтэн жилээр хоёр удаа хуваарилах болно.

- *Хэлэлцсэн 3-р асуудлаар гаргасан шийдвэр : Хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг үндэслэн Компанийн 2013 оны ногдол ашгийг хуваарилж тараасан мэдээлэл, 2014 оны ногдол ашгийг хуваарилсан болон 2015 оны ногдол ашгийг хуваарилах тухай мэдээллийг сайшааж, хурлын тэмдэглэлд оруулах.*

4. Компанийн ТУЗ-ийн болон Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал, зардлын төсвийн тухай. Хэлэлцүүлэгч ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн

ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн : Хурлын засварлага дууслаа, хэлэлцэх асуудалдаа орцгооё. Хурлын ирцийг одоо дахин танилцуулна уу.

Тооллогын комиссын гишүүн З.Гончигсүрэн : Хувьцаа эзэмшигчид нэмж ирснээр хурлын ирц 85.9 хувьтай болсныг мэдэгдэе.

ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн : За баярлалаа. Одоо та бүхэнд ТУЗ-ийн болон Гүйцэтгэх захирлын цалин урамшууллын зардлыг танилцуулж байна. Манай компанийн ТУЗ-ийн гишүүд нь хуралд оролцсон үедээ цалин авдаг, харин одоогоор урамшуулал олгоогүй байгаа болно. Гүйцэтгэх захирлын хувьд бол сарын үндсэн цалин болон урамшууллыг авч байгаа. Урамшууллын хэмжээг гүйцэтгэх захиралтай байгуулсан хөдөлмөрийн гэрээгээр зохицуулсан байдаг.

1. "Гермес центр" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь өнгөрсөн 2014 онд дараах зардлыг гаргаж зарцуулсан болно. Үүнд :
 - Цалингийн зардал нийт 10 340 000.00 төгрөг
 - ТУЗ-ийн гишүүн нь хуралд оролцсон тохиолдолд нэг удаагийн 350 000.00 төгрөгийн цалинг авдаг болно. Хуралд оролцоогүй тохиолдолд цалин олгогдоггүй болно.
2. "Гермес центр" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2015 онд цалингийн санд өөрчлөлт оруулахгүй. Үүнд :
 - ТУЗ-ийн дарга хуралд оролцсон тохиолдолд нэг удаагийн 410 000.00 төгрөгийн цалин – улиралд 1 удаа хуралдана
 - ТУЗ-ийн гишүүн хуралд оролцсон тохиолдолд нэг удаагийн 350 000.00 төгрөгийн цалин – улиралд 1 удаа хуралдана
 - Цалингийн нийт зардал 4 улирлаар тооцоход жилд 12 840 000.00 төгрөг байна. Урамшуулал олгохоор төлөвлөөгүй болно.
3. Компанийн Гүйцэтгэх захиралд 2014 онд дараах цалин урамшууллын зардлыг гаргасан. Үүнд :
 - Цалингийн зардал нийт 31 478 835.00 сая төгрөг
 - Компанийн ТУЗ-тэй байгуулсан контрактын дагуу олгосон урамшуулал 19 345 018.00 төгрөгийг олгосон.
4. Компанийн Гүйцэтгэх захиралд зориулан 2015 онд дараах цалин урамшууллын зардлыг гаргахаар баталсан болно. Үүнд :

• Цалингийн зардал нийт 31 478 835.00 сая төгрөг

- Компанийн ТУЗ-тэй байгуулсан гэрээний дагуу олгох урамшуулал нь гэрээний холбогдох заалтын дагуу тухайн жилийн төсөв төлөвлөгөө 100% биелэгдсэн тохиолдолд 15 800 000.00 төгрөг олгогдоно.

За та бүхэнд хэлэх санал шүүмжлэл байна уу. Хувьцаа эзэмшигчдийн зүгээс энэ асуудлаар байхгүй гэж хариуллаа.

- *Хэлэлцсэн 4-р асуудлаар гаргасан шийдвэр : Хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг үндэслэн Компанийн ТУЗ-ийн зардлын төсвийн тогтоолыг баталж, хурлын тэмдэглэлд оруулах.*

5. Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны тухай. Хэлэлцүүлэгч ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн

ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн : “Гермес центр”ХК-ийн хувьцааны 5-аас дээш хувийг нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийг уламжлал ёсоор танилцуулж байна. Хурлын материал хавсаргагдаж нийт хувьцаа эзэмшигчдэдээ хүргэсэн байгаа. Миний бие нь өөрийн гэр бүлийн хүн Д.Зоригтын хамт 65 990 160 ширхэг хувьцааг хамтран эзэмшиж байна. Асууж тодруулах зүйлс байна уу.

Компанийн нэр :” Гермес центр” Хувьцаат компани

Компанийн гаргасан хувьцааны тоо : 78 543 001

Мэдээлэл гаргасан огноо : Бүртгэлийн өдөр буюу 2014 оны 8-р сарын 15-ны өдрөөр

№	Нэгдмэл сонирхолтой этгээдийн овог, нэр	Эрхэлж буй ажил, албан тушаал	Эзэмшиж буй хувьцааны		
			Тоо ширхэг	Нийт хувьцааны хэдэн хувь болох	Энэ хувьд хүрсэн огноо
1	Даншзэвэг Зоригт	Иргэн	42 530 145	54.14 %	2014.08.15
2	Дугаржав Оюунсүрэн	“АСУ” сургуулийн захирал	23 460 015	29.87 %	2014.08.15
	Нийт		65 990 160	84.01 %	

Хувьцаа эзэмшигч Г.Мөнхэрдэнэ : Өөр том хувьцаа эзэмшигчид байна уу. Бүртгэлийн өдрөөр гарсан хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээллийг өгнө үү.

ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн : Хамгийн сүүлийн 2015 оны 2 сарын 28-ны бүртгэлийн өдрөөр манай компанийн нийт хувьцаанаас 5 хувийн хувьцааг “Импера Монголия холдинг” компани эзэмшдэг. Энэ компанийн хүмүүс нь турк хүмүүс байдаг, байнга бидэнтэй уулзаж, компанийн үйл ажиллагаатай тогтмол танилцаж байдаг. Бидний зүгээс ч үйл ажиллагаагаа нээлттэй үзүүлж танилцуулж байдаг. Компанийн 2 хувийг нэг хувьцаа эзэмшигч, 1 хувийг тус бүр 4 хувьцаа эзэмшигч эзэмшиж байна. Бусад хувьцаа эзэмшигчид нь 1 хувиас доош хувийг эзэмшдэг байна. Бүртгэлийн өдрийн байдлаар компани нь 902 хувьцаа эзэмшигчидтэй байна.

- *Хэлэлцсэн 5-р асуудлаар гаргасан шийдвэр : Хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг үндэслэн Компанийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн эзэмшилд байгаа хувьцааны мэдээллийг хурлын тэмдэглэлд оруулах.*

**6. Компанийн 2015 оны үйл ажиллагааны зорилт. Хэлэлцүүлэгч Гүйцэтгэх захирал
Ш.Баасанжав**

Гүйцэтгэх захирал Ш.Баасанжав : “Гермес центр”ХК-ийн 2015 оны үйл ажиллагааны зорилтыг та бүхэндээ товч танилцуулья. Манай компани нь

Орлогын хувьд : Тус компани нь 2015 оны эцэст 1 512 432 934.00 төгрөгийн цэвэр борлуулалтын орлоготой ажиллахаар төсөв төлөвлөгөөг ТУЗ-ийн хурлаар батлуулсан байгаа болно. Энэ нь борлуулалтын орлогыг 2014 оны гүйцэтгэлээс 145.4 сая төгрөгөөр буюу 10.6 хувиар өсгөж нэмэгдүүлнэ.

Зарлагын хувьд : Компанийн хэмжээгээр 2015 онд төлөвлөснөөр 847.7 сая төгрөгийн зардалтай ажиллана.

Ашигт ажиллагааны хувьд : Татварын дараах цэвэр ашиг төсөвлөснөөр 598.2 сая төгрөг байхаар төсөвлөв.

Бүтэц зохион байгуулалтын талаар : Компани нь 20 ажиллагсадтайгаар ажиллана. Авлагыг зохих хэмжээгээр барагдуулна. Төлөвлөгөөт ажлын хүрээнд худалдааны төвийн гадна өнгө үзэмжийг сайжруулж, гэрээт түрээслэгчидтэй нягт хамтран ажиллана.

Нэгж хувьцаанд хуваарилах ашиг нь : “Гермесцентр”ХК-ийн нэгж хувьцаанд 7 төгрөг 62 мөнгөний ногдол ашиг оногдохоор төлөвлөсөн.

Хувьцаа эзэмшигч С.Мягмарсүрэн : 2015 оны элэгдэл хорогдлын шимтгэлийг ямар аргаар тооцсон бэ. Ажиллагсдыг сарын дундаж цалин хэд вэ. Нийт түрээлж байгаа талбайн хэмжээ хэд вэ.

Нягтлан бодогч О.Энхтуяа : Элэгдэл хорогдлын шимтгэлийг шулуун шугамын аргаар тооцож боддог. Манай компанийн барилга байшин дээр хөрөнгө оруулалт нэмэгдсэн тул элэгдэл хорогдлын шимтгэл нь өнгөрсөн жилээс өсөж төлөвлөгдсөн. Компанид захиргааны болон үйлчилгээний ажилтан гэж байгаа. Манай компанийн ажилтны дундаж цалин бол 700 000-гаас 1400 000 төгрөг байна. Нийт ажиллагсдаа жилд 2 удаа буюу 6 сар тутамд урамшуулалт цалинг ажлын үзүүлэлтийг харгалзан олгодог. Эдгээр цалин урамшууллыг төсөв төлөвлөгөөндөө тусгасан. Улаанбаатар хот дахь Худалдааны төв өмнө нь 5922 м.кв талбайг түрээсэлж байсан бол барилгын засварын ажлыг хийж гүйцэтгэснээр одоо 6432 м.кв талбайг түрээсэлдэг болсон.

ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн : ТУЗ-ийн зүгээс ажиллагсдаа хэвийн хэмжээний цалин, урамшууллыг олгохыг зорьдог. Ажиллагсдын цалинг сүүлийн жилүүдэд байнга өсгөн нэмэгдүүлж байна. Тийм ч учраас манай компанийн ажиллагсад тогтвор суурьшилтай ажилладаг.

- *Хэлэлцсэн 6-р асуудлаар гаргасан шийдвэр : Хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг үндэслэн Компанийн 2015 оны үйл ажиллагааны зорилтыг сайшааж, хурлын тэмдэглэлд оруулах.*

7. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай. Хэлэлцүүлэгч ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн

“Гермес центр”ХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай.

ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн : “Гермес центр” ХК-ийн дүрмийн 4.2-т техникийн алдаа гарсныг Санхүүгийн зохицуулах хорооны ээлжит шалгалтаар илэрүүлсэн болно. Хорооны шалгалтын дараах зөвлөмжинд энэ алдаагаа хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн засах үүргийг

өгсөн. Иймд дараах өөрчлөлтийг оруулан, холбогдох хууль, журмын дагуу Санхүүгийн зохицуулах хороогоор хянуулж, улсын бүртгэлийн газарт бүртгүүлэх ёстой байна. Үүнд :

- Хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн буюу эргэлтэд гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь нэг бүрийн 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 23 562 900 ширхэг энгийн хувьцаа байна гэсэнг 78 543 001 ширхэг энгийн хувьцаа байна гэж өөрчлөх

ТУЗ-ийн нарийн бичгийн Б.Оюунцэцэг : Компанийн шинээр батлагдсан хуулийн дагуу бид хувьцаа эзэмшигчдийн 2012 оны 4-р сарын 30-ны өдрийн хурлаар дүрмээ шинэчлэн найруулж баталсан байсан бөгөөд энэ үедээ хувьцааны тоо ширхэгийг алдаатай бичсэн байна. Бид уг нь дүрмээ тухайн үед Санхүүгийн зохицуулах хороогоор хянуулж, улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн. Манай компани дээр 2014 оны эцэст Санхүүгийн зохицуулах хорооноос шалгалт орсон бөгөөд энэхүү шалгалтын явцад дүрмийн 4.2-р зүйлд алдаатай байгаа зөрчил илэрсэн юм. Мөн манай өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хуралд Санхүүгийн зохицуулах хорооны ажилтан хүрэлцэн ирж, хурлын үйл ажиллагаатай биечлэн танилцаж байна. Хувьцаа эзэмшигчид та бүхэнд хорооны ажилтанг танилцуулья. СЗХорооны КЗҮЗөвлөлийн даргын 2015 оны 4-р сарын 7-ны өдрийн 13/1819 тоот Албан бичгээр хувьцаа эзэмшигчдийн хурлын үйл ажиллагаанд үнэлгээ өгөх зорилгоор хорооны ажилтан ирж, хурлын үйл ажиллагаатай танилцаж байгаа юм байна.

ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн : Хурлын засварлагааны үеэр Санхүүгийн зохицуулах хорооноос ажилтан ирж, хурлын үйл ажиллагаатай танилцаж байгааг мэдлээ. Манай хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нээлттэй, ил тод, харилцан ойлголцлын хүрээнд явагдаж ирсэн. Хорооноос бидний явуулж байгаа үйл ажиллагаатай газар дээр нь ирж танилцсан явдалд баярлалаа. За одоо өөр санал асуудал байхгүй бол саналаа хураах уу.

Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар компанийн дүрмэнд дээрхи өөрчлөлтийг оруулж, компанийн дүрмийг батлав.

- **Хэлэлцсэн 7-р асуудлаар гаргасан шийдвэр : Хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг үндэслэн Компанийн дүрмэнд өөрчлөлтийг оруулан компанийн дүрмийг тогтоолоор баталж, хурлын тэмдэглэлд оруулах.**

ТУЗ-ийн дарга Д.Оюунсүрэн : За хуралдаа морилон ирсэн хувьцаа эзэмшигч та бүхэндээ баярлалаа, одоо та бүхэн бөглөсөн саналын хуудсаа манай тооллогын комиссын гишүүдэд хүлээлгэн өгнө үү. Бидний үйл ажиллагааг дэмжиж, ойлгож ирсэн хүндэт хувьцаа эзэмшигчдэдээ чин сэтгэлээсээ баярлаж байна. Та бүхэн манай худалдааны төвийн өөрчлөлт шинэчлэлтийг газар дээр нь үзэж сонирхож болно. Өөр санал, хүсэлт байхгүй бол хурал үүгээр өндөрлөснийг мэдэгдэе.

“Гермес центр”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал нийт 3 цаг 20 мин үргэлжилж, 18 цаг 30 минутанд дуусав. Хурал амжилттай болж өнгөрлөө.



Хурлын тэмдэглэлийг хөтөлсөн :

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Оюунцэцэг

Хурлын тэмдэглэлийг хянан баталсан :